

УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

**ШАШИН НОМЫН ДЭЭД ЦОЛ-ГАВЬЖ,
АГРИМБА ХҮРТЭЭХИЙН УЧИР**

Өгүүлэх нь: Уншигч судлаач Та бүхний хэнд ч магадгүй, ялангуяа хуучин архив, ном судар, данс бичиг, түүх шастир эмхтгэж байхад чинь шар, цагаан даавуун дээр хар бэхээр дармалсан «үнэмлэх бичиг» дайралдаж магадгүй, харин үүнийг манай судлагч эрдэмтэн мэргэдээс ялангуяа дорнодахины судалгаа шинжилгээнд холбогдуулан соёл дурсгалын хувьд судалж үзэхэд их сонин юм. Энэ талаар учир утгыг нь тодорхойлоход нэлээд сонин түүх өгүүлнэ. Судлаач би 1960—1970-аад оны хооронд хөөцөлдөн сурвалжилж, хуучин Их хүрээний Гандан дээр олон жил сууж Гавьж (арван бэрх) Агримба-тарний зэрэг гол авч байсан Агримба Ц. Лувсангомбо, Гавьж Н. Эрдэнэлэл, С. Гомбожав, Сэмбээжав, Ж. Чүлтэм (ажаа), Гэвш Ш. Лхамаажав, Шадав (буриад) зэрэг арваад хүнтэй уулзаж ярилцсан билээ. Тэгэхэд энэ үнэмлэхний учир утгыг нэлээд судалсаар байтал бичих зүйл бүрдэл боллоо. Дээр уулзаж байсан нэр бүхий олон лам нар цөм нас эцэслэжээ. Би нэгэнт судалсан ийм зүйлийг мэдсэн үзсэний хирээр эрдэм шинжилгээний сэтгүүлд бичин хүмүүсийн мэдлэгийн санд үлдээх нь маш чухал буй за. Үүнийг сурвалжлан бичих гэж олон жил болсон доо. Энэ тухай тодруулан өгүүлэх нь: Энэ үнэмлэхний модон барыг анх 1933—1934 оны өвөл Их Хүрээн дэх тэр үеийн шашны захиргааны газраас эрхлэн уран Дэндэв (чөтгөр) гэдэг ламаар «хуш модоор» сийлүүлжээ. Энэ үнэмлэх бол 15x20 см, захаар нь бадамлянхуан эрхсийн дотор Дашдагжид буюу өлзийт найман тэмдгээр хүрээлэн сийлжээ.

Энэ найман тэмдгийг төвдөөр:

Ринчин-дүгдан-сэр-ня-дан
Дэрчин-бумба-бадама-сан
Дунгар-яйчил-балвий-үй

Чогий-Жанцан-хорлоо-сог, гэж магтаал болгон шүлэглэж

уншдаг ном байдаг. Үүнийг монголчилвол: 1. Эрдэнийн цагаан Шүхэр, 2. Амгалан оршигч Алтан загас, 3. Их эрдэнийн баян хумах (бумба), 4. Үнэр сайт цагаан лянхуа цэцэг, 5. Яруу цуурайт цагаан лавай (дун бүрээ), 6. Өнө энхийн өлзийт утас, 7. Эрдэнийн дээд дууз чимэг, 8. Их эрдэнэт алтан хорлоо зэргийг өлзийт найман тэмдэг гэнэ. Тэгээд энэ үнэмлэхийг цагаан ямбуу даавуун дээр хар бэхээр барлаж тэр үед Их хүрээнд байсан Шашны төв захиргааны том дөрвөлжин соёмбо ба монгол үсэг бүхий тамга даржээ. 1965 онд Гандантэгчилэн хийдийн лам, хуучин Сангай аймгийн гавьж Ажаа Чүлтэм гуай өөрийнхөө 35 тоот үнэмлэх, бас шүтээний аймгийн Агримба Чимэд 518 тоот үнэмлэх 2-ыг Чи түүх хөөцөлддөг хүн, чамд өгье. Хойно нэг цагт хэрэг ч болж юу магад хэмээсэн учир миний хувийн архив-хадгаламжинд үндсэн эх үнэмлэх нь байгаа билээ.

Тэгээд үгийг сийрүүлвээс:

Монгол улсын 26 он 4-р сарын 15, дугаар 35, (1936) он юм. Улаан баатар хот дахь Гандан хүрээний шашны захиргаанаас үнэмлэх олгосны учир: Эдүгээ манай хүрээний Сангай аймгийн Чүлтэм нь (Чойран) ном дор боловсрон Дашчойнпэл дацан дор гавжийн дамжаа барьж, бас Даж эргүүлж мэндаг олсон нь үнэхээр номын ёсноо шал гарсан этгээд тул олон лам нараас түүнийг тусгайлан хүндэтгэж үзвэл зохино.

Эрхлэгч Хайдав

Туслах Лувсангомбо гэж монгол үсгээр дармалсан үнэмлэх байв. Энэ үнэмлэхийг гаргаж олгох болсон нь 1935-1936 онууд Гандан дахь

Дашчойнпэл (1756) онд байгуулсан Гунгаа-чойнзинлин (Зүүн дацан) (1809) онд, Идгаачойнзинлин (1910) (Хойт дацан) Зүүн хүрээн дахь Жүд-дацан 1807 онд байгуулсан дацангуудад Буддийн гүн ухааны ном онолд суралцах сургуульд орж зиндаа анги алгасалгүй сурч Чойрын таван ботьны ном үзэн төгсгөж шалгуулаад цол авдаг байв.

Эдгээр нэр бүхий дацанд эртний дорнодахины Энэтхэг Төвдийн их эрдэмтэн Банчин Содномдавгийн Игчаа-сурах бичгээр, Зүүн дацанд Гунтан Жамъяншадав Игчаагаар, Баруун дацанд Сэр Жавзүнва Лувсанчойжижалцаны Игчаагаар, Хойт Дацанд тус тус суралцдаг байжээ. Энэ дацангуудад эртний гарамгай эрдэмтэн багш Нагар-жунай, Асанга, Васубанду, Шантидева, Богд Зонхова түүний гарамгай мэргэн шавь Гэндэндүва, Жалцавжи, Хайдавжи нарын зохиосон Игчаа (сурах бичиг) номуудыг дээр нэр дурьдсан дацангуудад 1-р анги хадаг шидэв II-Жүнбарай. III-Юлжин, IV-Дондонжүү, V-Ог гом, VI-Гавдамба, VII-Дом, VIII-Ум сарв, IX-Ум нямба, X-Гаарамба ийм арван анги-зиндаанд тасралтгүй суралцах боловч бас лам нар багшийнхаа зөвшөөрлөөр Зиндаа бууж (анги доошлох) номоо улам давтан үзнэ. Ном их сайн үздэг зарим лам нар анги-зиндаа өгсөх ч тохиолдол байжээ. Уул Дацангуудад үзэх ном гэвэл Парчин-Билэг Бармид-Орчлонгийн чандад одох ухааны ном. Прмана-Учир шалтгааны ухаан, Мадъямига-Төв үзлийн ухаан, Авхидхарма-Илт өгүүлэх номын ухаан, Виня-Номхотгохын ухаан зэрэг энэ таван ботийг үзэж бас түүний «таван дэлбээ» тайлбар сэлт Арван бэрх ухааны номыг үзэж төгсгөөд тус бүрийн шүүлэг өгсөөр яваад (Гавжийн дамжаа) гурван өдөр барьж дунджаар 500 гаруй лам нарын ээлжлэн босож тавьсан (номын асуулт)-ыг хариулж гүйцээд мэндаг цолоо авч (Гавж) болдог байжээ. Гавьж болсны дараа Зүүн хүрээнд Сан-аг-дичинлин буюу жүд хэмээх дацанд орж Сандуйн жүдээс эхлэн Жүд-Шихайн дөрвөн үндэсний ном; Грия тантра, чаръя ёк, ёкануттра гэх мэт Мах-яна буюу дээд хөлгийн номыг тайлбар сэлт нь дөрвөн жил үзэж гүйцээд жинхэнэ таринь номыг үзэж мэргэжсэний дамжааг барьж Агримба болж цолоо хүртдэг байжээ. Гавж Агримба болж ном эрдэмд сайжирьяа гэвэл доод тал нь 15—20 жилийн хугацаа элбэг орох юм. Ер нь дээр үед Их хүрээнд Гавьж-Агрим ба бологчид маш цөөн бөгөөд дамжаа баригчид нь номоороо гайхагдсан сайн чанартай байсан олон баримт байдаг. Жишээ нь: Энэ тухай Монголын IV богд Жавзүндамба Лувсантүвдэнванчигийн их намтарт үзэхэд: Тэнгэр тэтгэгчийн 46-р он буюу 1781 онд Их хүрээнд гэвш Лувсандорж, Сономцэдэн гэдэг хоёр лам анх удаа гавьж болжээ. Дараа нь Сайшаалт ерөөлтийн II-р он буюу 1807 онд Гэвш Жамц Содномдаваг гэдэг хоёр лам анх удаа агримба болжээ. Энэ үед Гавьж, Агримба бологчдод Богдоос дээлийн бүхэл шар хамба, залуу морь шагнадаг байсан гэдэг. Түүнээс хойш энэ уламжлалаар олон он жил болж дамжаа баригчдын тоо ч олширчээ. Тэгээд дамжаа баригчдад (шар хамба бүхэл) шар торго буюу пүүсүү эд дээр хар бэхээр дарсан Ножин-Аварзэд, Ножин Дагдаа гэдэг Баян Намсрай бурхны хоёр нярвыг Аюуш хадгийн хамт шагнаж урамшуулдаг нэг ёс нэлээд уджээ. Чойр-цанидын дацанг зиндааны эрэмбээр дагаж таван ботины дамжаагаа сайн баригч Гавьж Агримба болсон мэндагтан нар нь Монголын аль ч сүм хийдэд очиход (шар цоохор) олбог дээр суудаг эрэмбэ дараатай байсаар иржээ. Ер нь шар цоохор олбог бол шашны нэг төрлийн их хүндэтгэл бөгөөд олон лам нараас дамжаа барьсныг хүндэтгэж байгаа их хүндэтгэл юм. Харин бүүр сүүлд 1920-1928 оны үед Гандан хүрээ болон Хүрээ хөдөөд байсан Чойр дацангаас жилдээ 30-40 хүн гавьж агримба болж байжээ. Энэ тухай 1937 оны нэгэн бүртгэл мэдээгээр

Хүрээ хөдөөд Гавьж мэндагтан 2496, Агримба 392 хүн байсан баримт байдаг. Энэ тухай 1925 онд Их хүрээний шашны яаманд алба хашиж, сүүлд Гандантэгчилэн хийдийн хамба болсон Найдангийн Эрдэнэпил, Цогчин их гэсгүй байсан Т. Гомбодоо, их умзад байсан Ц. Лувсангомбо (Агримба), Гавьж Данзан-Осор нарын хэдэн лам нарын яриа тэмдэглэлээс үзэхэд бүүр ч тодорхой, тэд ярихдаа Гавьж-Агримба бологчдод цол-мэндаг олгох явдал эрс олширч, жинхэнэ номоор мэндагтан болохын оронд өглөг (гурил-шар тос)-ийн мэндаг авагчид эрс олширч чанар нь доройтсон юм. Тэгээд энэ байдлаас болж 1935—1936 онд хуралдсан Их Хүрээний Шашны яамны IX их хурлын тогтоолоор мэндагтан нарыг номоор шалгаж, Хүрээ-хөдөөгийн Чойр жүд Дацангийн Гавьж-Агримба нэртэй 1500 шахам хүнийг дахин шалгалт шүүлэг авч Онц-сайн дүнтэй мэндагтан лам нарт энэ үнэмлэхийг олгож эхэлсэн юм. Тэгээд Шашны яамны эрх баригч Эрдэнэпил, Гомбодоо, Шадав, Рэнчинхорлоо нар хэлэлцээд дээр дурдсан энэ үнэмлэхийг (Алтан шармал, мөнгөн) хатуу эдээр хийсэн хавтастай үзэмжтэй одоогийн (диллом) шиг болгох санаатай Хойт Буриадын эрдэмтэн Жамсранов тэр үед Орос багш гэж байсан Тувак нартай ярьж тохироод Чөтгөр Дэндэвийг уул үнэмлэхийг үзэмжтэй хийлгэхээр Улаан-Үд явуулах гэж байтал 1937—1938 он гарч хэлмэгдлийн ажил эхэлж уул асуудал бүхлээрээ унтарсан хэрэг гэж ярьсан билээ. Тэгээд энэ нэгэн үнэмлэх бичгийн тухай олон жил материал цуглуулан судлахад ийм байна. Тархи оюунаа зовоож хөөцөлдсөний хувьд хойшид хэдэн зүйлийн учрыг нэмж бичих нь бүр ч сонин мэт санагдлаа.

Өгүүлвээс: Одоо манай оронд өөрчлөлт шинэчлэлтийн үе ид өрнөж, хуучин уламжлал ёс заншил сэргэж байгаа өнөө үед бид хуучин соёл түүх, эрдэм номоо эргэн харж судлах явдал тавигдаж байна. Тухайлбал: 1935 оноос хойш 56 жил нэр нь ч дуулдахаа байсан гавьж, агримба болох жинхэнэ эрдэм номын үйлс алга болсон боловч сайн цагийн эргэлт болж энэ өнгөрөгч цагаагчин морин жилд Гандантэгчилэн хийдэд Цорж Г.Осорхамба, Т. Дамдинсүрэн (Хамба), Гэвш Сайннямбуу, Гэвш Д. Жигмид-Осор, Гэвш Давагжанцан нарын зургаан лам удаа дараа дамжаа барьж Гавьж гэдэг эрдэм-номын мэндагтан болсон нь шашин бурхны түүхэнд тэмдэглэлт үйлс боллоо. Эдгээр сайхан үйлсийн зам мөрийг ажиглахад эрдэм-номын цол хүртэгчдэд хүрэхүйц өндөр настай боловч нэгэн насаар ном судар шагайж суугаа Гэвш Жамсран, Жамбалдорж (Архангай), Лувсанням (Төв аймаг), Цэдэн-Иш (УБ хотын), Ишжанцан (Баянхонгор), Итгэл (Булганы) нарын эрдэмтэн өвгөчүүлийн нэрийг дурьдмаар байна. Сүүлийн үед Гавьжийн мэндаг олгохдоо бас эрдэм номын мэдлэг чадвар, ертөнцийн үзэмжээр олны дунд нэр хүнд байр суурийг бас л нэгэн адил харж дүгнэх цаг тулжээ. Нийгмийн байр суурь алдар нэрээ олны дунд гутаагч Цэдэнбалын далбаан дор хоргодож, түүнийг тойрон хүрээлэгчид шиг ард түмний мөн бурхны шавь биднийгээ мал-мануухай шиг залилсан этгээдүүдэд шашин төр аль нь ч өндөр алдар цол өгч, цалин мөнгө цутгаад байвал (тэд сэтэртэй малаас) юу нь ялгах вэ? гэж оюун ухаандаа тунгааж бодном. Тийм хүмүүс түрүүчээсээ эхлээд шигшигдэж байгааг нүдээр харж чихээр сонсож байна. Гандэнтэгчилэн хийдэд Чойрын гурван дацан Ламриндацан, учир утгаа мэдэхээ байсан харчуулаар бүрдсэн эмч-зурхай дацан, Жодын хурал, эмэгтэйчүүдийн хурал гэж нэрлээд тэнэж яваа хэсэг хүмүүсийн чиг зүгийг нь олж, тэднийг байр орон, сүм дугантай болгож (нэр хаягнаас авахуулаад) хуучны түүхээ бодож шинэ өөрчлөлт хийх нь Монголын Шашинтны Төв, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны асуудал эрхэлсэн ажилтан нөхдөд

нэгэн адил тулгараад байна шүү! Ийм шинэ байгууламжийг Монгол лам нар өөрийнхөө оронд өөрсдөө зоригтой түргэн хийж шийдэх цаг үе болсон шиг санагдана.

Арван цагаан буян дэлгэрэн
Өлзий хутаг орших болтугай
Ум-ма-ни-бад-ми-хум,

Лам. Н. Дашзэвэг (Бурхны шашны
түүх судлагч)

Тайлбар

- I Агримба — Тарний номтны дээд цол
- II Гавьж — Арван бэрх
- III Мэндаг — Нэр алдар
- IV Даж-эргүүлэх —Тусгай бэлтгэсэн сум эргүүлэх (бурханы бие) зарлиг, таалал гурав
- V Дамжаа – Шүүлэг, ам авч (цол хамгаалах)
- VI Даш-дагжид — Өлзийт наймаг тэмдэг
- VII Жүд-үндэсний дацан—Зүүн хүрээнд байсан
- VIII Дашчойнпил—Зүүн дацан
- IX Гунгаачойлин — Баруун дацан Гандан дээр байсан
- X Идгаачойнзинлин — Хойт дацан